
МЭДЭЭ · 2021 оны 3-р сарын 11

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРААС ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ



Сэлэнгэ аймгийн прокурорын газраас аймгийн цагдаагийн газартай хамтарсан сургалт, зөвөлгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, 2020 онд аймгийн прокурорын газраас цагдаагийн газарт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хууль хэрэгжүүлэх талаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, үр дүнтэй танилцжээ. Мөн зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих ахлах прокурор А.Ариунзаяа Танхайрах болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлийг шалган шийдвэрлэхэд анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж, аймгийн хэмжээнд явагдаж байгаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх аяны явц байдалтай танилцан үүрэг, чиглэл өгсөн байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2806